

БАТЛАВ

ДАРГА

Ч.НЭРГҮЙ

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

**УСНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт /
гэрээний нэр:

*“Ногоон байгууламжтай талбайд усны нөөц бүрдүүлэх,
усалгааны нөхцөлийг сайжруулах /Хэрлэн сум/” ажил*

Тендер шалгаруулалт /
гэрээний дугаар:

БОХНСЗ-2.1.6/2020

**Чойбалсан хот
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.01.15

Тендер шалгаруулалтын дугаар: БОХНСЗ-2.1.6/2020

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *“Ногоон байгууламжтай талбайд усны нөөц бүрдүүлэх, усалгааны нөхцөлийг сайжруулах /Хэрлэн сум/”* ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь *цахим Төрийн худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын/ www.tender.gov.mn дээр байгаа/ дагуу зохион байгуулж байна.*

/Цахим тендерийн урилга 50,000 төгрөг/

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг *2020 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 10 цаг 00 минутаас* өмнө ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан *2020 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 10 цаг 10 минутад* нээнэ.

Орон нутгийн давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,
Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар,
Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар
Утас: 7058-3058
Факс: 7058-4058*

*Цахим шуудан: info@umch.dd.gov.mn
Цахим хуудас: www.umch.dd.gov.mn, www.tender.gov.mn*

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТООЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжих 30,0 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Ногоон байгууламжтай талбайд усны нөөц бүрдүүлэх, усалгааны нөхцөлийг сайжруулах /Хэрлэн сум/” ажил гүйцэтгэх үнийн саналыг дараахь мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан байх/ • Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай. • Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, • Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт, • Харилцагч банкны тодорхойлолт, • Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртгийн дүнгээс 50 хувиас багагүй байх /банкны тодорхойлолт, дансны үлдэгдэл/ • Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 80%-аас багагүй байна. • Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онд төсөвт өртгийн үнийн 50 хувиас багагүй дүнтэй тухайн ажилтай ижил төстэй ажилыг гүйцэтгэсэн байх. /туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/; • Тохижилтын ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, дүрмийг мөрдлөг болгох, ашиглагдах бараа, материал нь холбогдох чанарын шаардлага болон энэхүү тендерийн техникийн тодорхойлолтыг хангах тухай мэдэгдэл, • Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу тохижилтын ажилд ашиглах Монгол улсын гарал үүсэлтэй бараа, материалын жагсаалт гаргаж ирүүлэх, <p>Тендерт оролцогч тухайн ажилд Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас олгосон дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p>1. Цооног өрөмдөх, сэргээн засварлах, тоноглох</p> <p>2. Усны барилга байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх</p> <p>Гэрээг гүйцэтгэхэд дараахь мэргэжилтэй ажилчид шаардлагатай бөгөөд үндсэн ажилтан байна. Нэг ажлын байранд нэг хүн санал болгоно. /сүүлийн 3 сарын нийгмийн даатгалын тооцооны хуудас, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбарыг хавсаргана/. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гидротехникийн инженер - Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны ажилтан <p>Дараахь үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <p>1. Өрөмдлөгийн машин</p> <p>2. Бусад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл</p> <p>Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг, Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар, Орон нутгийн өмчийн газар,</i></p> <p>Огноо: <i>2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 00 минут</i></p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба оролцож байгаа тендерийн нэр, дугаарыг гаргацтай тэмдэглэнэ.</p> <p>Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мб-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Мб-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p><i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газар</i> <i>Утас: 7058-3058</i> <i>Факс: 7058-4058</i> <i>Цахим шуудан: info@umch.dd.gov.mn</i> <i>Цахим хуудас: www.umch.dd.gov.mn</i> <i>Ш/Х-250</i></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр</i> Цаг: <i>10 цаг 10 минут</i></p> <p><i>Үнэлгээний хорооны өрөөнд болно</i></p> <p><i>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</i></p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Үүнд: <i>Багцгүй</i></p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ ТАЛБАЙД УСНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, УСАЛГААНЫ
НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ //ХЭРЛЭН СУМ/ АЖЛЫН ДААЛГАВАР

ЖЮА0005

2019.12.27.

Чойбалсан хот

	Ажлын шалгуур
Ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	Худаг ус гаргах, усжуулах чиглэлийн ажлын дадлага туршлагатай, мэргэжлийн боловсон хүчинтэй аж ахуйн нэгж байна.
	Өмнө жилүүдэд хийсэн ижил төстэй бусад ажлыг хүлээлгэн өгсөн акт, өмнө гүйцэтгэсэн гэрээний хувийг хавсаргасан байна.
	Ажлын талбайд хэрэглэгдэх бараа, материал нь гарал үүслийн гэрчилгээ, чанарын сертификаттай байх шаардлагатай.
	Гүйцэтгэгч нь ажлын багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжтэй, ачааны автомашинтай байна.
Ногоон байгууламжтай талбайд усны нөөц нэмэгдүүлэх ажил	Усалгааны нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 9 дүгээр багийн нутагт 1 цооног гаргана. Хэрлэн сумын 7, 9 дүгээр багийн нутагт гаргасан цооногийн дэргэд 4 ширхэг монгол гутал хэлбэртэй 2-2.5 тн багтаамжтай ус нөөцлөх савыг шинээр хийж суурилуулна. /Зураг хавсралт 1/ Энэ нөөцлөх савны хийц материал нь 2-4 мм-ийн зузаан лист төмөр байна. Ус нөөцлөх савны гадна талыг зэврэлтээс хамгаалж төмрийн будгаар будаж, хээлнэ. Нөөцлөх сав бүрт тохирсон 50метр урт төмөр усалгааны хоолой, 300 метр урт шланжийг дагалдуулж хүлээлгэн өгнө.



Тав. **ЖИШИГ МАЯГТ**
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүй танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| 7. Ажлын хөтөлбөр | Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах,

хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> ⁴
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/
Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны __ дугаар сарын ____ -ны өдөр эхэлж, _____ оны __ дугаар сарын ____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]